

ШАТАХУУНЫ КАРТЫН ГЭРЭЭ

2012 оны сарын өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх) нэг талаас Монгол улсын хуулийн этгээд болох “Петровис Карт” ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Т.Оюунбилэг цаашид (“Картаар үйлчлэгч” гэх), нөгөө талаас МУ-ын хуулийн этгээд болох-г төлөөлж.....цаашид(Карт эзэмшигч гэх), нар хамтад нь Талууд гэх, дараах нөхцлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 **Картаар үйлчлэгч** шатахууны картын захиалгыг хүлээн авч бүртгэснээр Талууд хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээ болон Монгол Улсын Иргэний хуулиар зохицуулна.
- 1.2 **Картаар үйлчлэгч** нь биет байдлын болон эрхийн доголдолгүй чанарын шаардлага хангасан шатахууныг карт эзэмшигчид нийлүүлэх, карт эзэмшигч нь энэхүү гэрээнд заагдсан нөхцлийн дагуу шатахууны төлбөрийг төлөхөөр тохиролцов.
- 1.3 **Карт эзэмшигч** нь картаар үйлчлэгч талаас санал болгож буй картнуудын төрөл, тоо хэмжээг хязгаарлахгүй авч болох ба тухайн тохиолдолд хавсралтанд нэмэлт хийнэ.
- 1.4 Гэрээний хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 1.5 Карт эзэмшигчийн авсан шатахуун хэмжээгээр, тухайн станцад мөрдөгдөж байгаа үнийг харгалзан картаар үйлчлэгч картанд урьдчилан төлсөн төлбөрөөс хасалт хийнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Энэхүү гэрээ нь Талууд гэрээнд заасан нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж энэхүү гэрээний 6.1-д зааснаар дуусгавар болно.

Гурав. Картаар үйлчлэгчийн эрх, үүрэг

- 3.1. **Картаар үйлчлэгч** нь карт эзэмших захиалгыг хүлээн авч гэрээ байгуулж картыг олгох үүрэгтэй.
- 3.2. **Картаар үйлчлэгч** нь карт эзэмшигчийн шилжүүлсэн мөнгөнд чанарын шаардлага хангасан шатахууныг олгох үүрэгтэй.
- 3.3. **Картаар үйлчлэгч** нь **Карт эзэмшигчийн** шилжүүлсэн мөнгөн дүнг ерөнхий дансанд байршуулах ба карт тус бүрт хуваарилах дүн, лимитэнд орох өөрчлөлт зэргийг албан бичгээр гаргасан хүсэлтийн дагуу гаргаж өгөх үүрэгтэй
- 3.4. **Картаар үйлчлэгч** нь лимитийн карт эзэмшигчийн ерөнхий дансанд нөөц мөнгө байршуулаагүйгаас гарсан төрбөрийг 3 хоногийн дотор барагдуулаагүй тохиолдолд нийт дансыг хаах эрхтэй.
- 3.5. **Хавсралт 1-д** дурдсан шатлалын дагуу өмнөх сарын нийт худалдан авалтын үнийн дүнгээс урамшуулал олгох ба урамшууллыг данс, карт цэнэглэх хэлбэрээр олгох үүрэгтэй.
Урамшуулал цэнэглүүлэх картын дугаарыг албан бичгээр гаргасны дагуу цэнэглэх эрхтэй.
- 3.6 **Картаар үйлчлэгч** нь карт эзэмшигчийг шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.
- 3.7 **Картаар үйлчлэгч** нь картын төвд нээгдсэн ерөнхий дансанд мөнгөтэй тохиолдолд картын үйлчилгээ ороогүй ШТС-с шатахуун олгоно /Энэ заалт нь орон нутагт зайлшгүй тохиолдолд хэрэгжинэ./
- 3.8 **Картаар үйлчлэгч** нь карт эзэмшигчийн картын төвд байршуулсан мөнгөнд зөвхөн шатахуун олгох үүрэгтэй
- 3.9 **Картаар үйлчлэгч** нь **Карт эзэмшигчид** интернэт ашиглан картын үлдэгдэл болон гүйлгээгээ шалгах, ерөнхий данснаас карт руу хувиарлалт хийх эрхийг олгох үүрэгтэй.
- 3.10 ШТС-д картаар шатахуун худалдан авсан анхан шатны баримтыг 2 хувь үйлдэж, 1 дэх хувийг **карт эзэмшигчид**, 2 дахь хувийг **картаар үйлчлэгч** компани авч 6 сар хадгална.

Дөрөв. Карт эзэмшигчийн эрх, үүрэг

- 4.1 **Карт эзэмшигч** нь гэрээний хавсралт 2-т дурдсан Петровис ХХК, НИК ХХК-ийн салбар ШТС-уудаас шатахууныг картаар үйлчлүүлэх эрхтэй.
- 4.2 Картын төвд нээгдсэн ерөнхий дансанд мөнгөтэй тохиолдолд картын үйлчилгээ ороогүй ШТС-д үйлчлүүлнэ./Энэ заалт нь орон нутагт зайлшгүй тохиолдолд хэрэгжинэ./
- 4.3 **Карт эзэмшигч** нь худалдан авсан шатахууны хэрэглээний 1 жилийн доторх хугацааны тайланг карт бүрээр дэлгэрэнгүй болон нэгтгэсэн хэлбэрээр хүссэн үедээ бичгээр болон e-mail-ээр авах эрхтэй.
- 4.4 **Карт эзэмшигч** нь картын төвд байршуулсан мөнгөндөө зөвхөн шатахуун худалдаж авах үүрэгтэй.
- 4.5 **Карт эзэмшигч** нь **картаар үйлчлэгчийн** дансанд карт цэнэглэх төлбөрийг урьдчилан шилжүүлж картыг цэнэглүүлэх буюу карт эзэмшигчийн итгэмжлэгдэн код авсан ажилтан интернетээр картуудаа цэнэглэх үүрэгтэй.
- 4.6 **Карт эзэмшигч** нь энэ гэрээний 4.5 дахь хэсэгт заасан итгэмжлэгдсэн ажилтанг бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 4.7 **Лимитийн карт эзэмшигч** нь ерөнхий дансандаа нийт картуудад тогтоосон лимитийн 1 хоногийн дүнтэй тэнцэх хэмжээний мөнгийг урьдчилан байршуулах үүрэгтэй.
- 4.8 **Лимитийн карт эзэмшигч** нь ерөнхий дансанд нөөц мөнгө байршуулаагүйгаас гарсан худалдан авалтыг 3 хоногийн дотор барагдуулах үүрэгтэй.
- 4.9 **Карт эзэмшигч** нь картаар үйлчлэгч байгууллагаар алсын цэнэглэлт хийлгэх хүсэлтэй, 2-с дээш карт эзэмшдэг бол карт тус бүрт хуваарилах мөнгөн дүн, лимитийн өөрчлөлт хийх дүнгээ факсаар илгээнэ.
- 4.10 Картыг картын төвөөр алсаас цэнэглүүлсэн тохиолдолд цэнэглүүлсэн хугацаанаас хойш 30 хоногийн дотор ШТС-н Пос машинд тухайн картыг уншуулж, картаа цэнэглэнэ.

- 4.11 **Карт эзэмшигч** нь интернэтээр картын дэлгэрэнгүй тайлан авах, харах хянах кодыг гэрээ хийснээр авах ба карт цэнэглэх нэмэлт цэсийг итгэмжлэгдсэн ажилтандаа албан тоотоор картын төвд хандаж авна. Интернет кодыг авсаны дараа эрх бүхий ажилтан нь интернет кодоо сольж нууцлалаа баталгаажуулах үүрэгтэй.
- 4.12 **Лимитийн карт эзэмшигч** нь картын лимитийн хэмжээг өөрчлөх, зогсоох тухай хүсэлтээ албан бичгээр картаар үйлчлэгчид гаргаж өгөх үүрэгтэй.
- 4.13 **Карт эзэмшигчийн** итгэмжлэлт өөрчлөлт орсон тохиолдолд албан бичгээр картаар үйлчлүүлэгчид зөвхөн бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 4.14 Хэрэв 4,11, заалт хэрэгжээгүйгээс үүсэх хохирлыг Картаар үйлчлэгч байгууллага хариуцахгүй.
- 4.15 Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний Хавсралт №3-т заасан карт ашиглах журмыг **карт эзэмшигч** бүрт /жолооч нарт / танилцуулсах үүрэгтэй.
- 4.16 Интернет кодийг 3 удаа буруу оруулсан тохиолдолд картын төвд хандах, дахин кодоо сэргээж авах эрхтэй.
- 4.17 **Карт эзэмшигч** нь Картаар үйлчлэгчийн зөвшөөрөлгүйгээр картыг өөр этгээдэд худалдах, шилжүүлэхийг хориглоно. Зайлшгүй тохиолдолд энэ тухай урьдчилан албан тоотоор мэдэгдэнэ.
- 4.18 **Карт эзэмшигч** нь картын нууц кодыг /PIN code/ задруулахгүй, алдагдахаас хамгаалах үүрэгтэй.

Тав. Төлбөр, тооцоо

- 5.1 **Карт эзэмшигч** нь шатахууны картын үнийг төлснөөр карт эзэмших эрхтэй болно. Ашиглалтын хугацаанд шимтгэл төлөхгүй болно.
- 5.2 **Карт эзэмшигч** нь **Картаар үйлчлэгчийн** харилцах дансанд карт цэнэглүүлэх мөнгөн дүнг урьдчилан шилжүүлнэ.
- 5.3 **Лимитийн карт эзэмшигч** нь ерөнхий дансны нөөц мөнгө дууссан үед гарсан худалдан авалтын төлбөрийг 3 хоногийн дотор картаар үйлчлэгч байгууллагад шилжүүлнэ.
- 5.4 **Карт эзэмшигч** нь тооцоо нийлсэн актыг улиралд 1 удаа баталгаажуулж авна.

Зургаа . Гэрээг цуцлах

- 6.1 Дараахь нөхцлүүдэд гэрээг цуцална. Үүнд:
- 6.1.1. Талууд энэхүү гэрээг цуцлах талаар албан ёсоор харилцан тохиролцсон тохиолдолд,
- 6.1.2. Аль нэг тал энэхүү гэрээний биелүүлээгүй болон аль нэг талаас гэрээг цуцлах хүсэлтээ бичгээр 7 хоногийн өмнө цуцлах үндэслэлийн хамт хүргүүлсэн нөхцөлд,
- 6.1.3. Картаар үйлчлэгчийн зөвшөөрөлгүйгээр картыг дур мэдэн бусдад шилжүүлсэн тохиолдолд,

Долоо. Гэрээний хариуцлага

- 7.1 Картын PIN код болон итгэмжлэгдсэн ажилтанд өгсөн интернет код алдагсанаас үүсэх хохирлыг **Картаар үйлчлэгч** хариуцахгүй .
- 7.2 Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг аль буруутай тал хариуцана.
- 7.3 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас (цахилгаан, импортын хязгаарлалт, хомсдол, холбоо болон шугам сүлжээний доголдол г.м) аль нэг тал үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ талаар протокол үйлдэх ба аль нэг тал хариуцлага хүлээхгүй.
- 7.4 Карт эзэмшигч нь энэхүү гэрээний 4.12-д заасан үүргээ зөрчсөнөөс картаар үйлчлэгчид учирсан хохиролыг 3 хоногийн дотор барагдуулна.

Найм. Бусад

- 8.1 Талуудын гэрээний биелэлтийг дүгнэх, гэрээнд болон гэрээний хавсралтад аливаа нэмэлт өөрчлөлт оруулах бол 2 хувь үйлдэн эрх бүхий төлөөлөгчид албан ёсоор баталгаажуулна.
- 8.2 Энэхүү гэрээний явцад гарсан аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тийнхүү шийдвэрлэж чадахгүй тохиолдолд МУ-ын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.
- 8.3 Гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд хувиуд нь хуулийн өмнө адил тэнцүү эрхтэй байна.

Ес. Талуудыг

төлөөлж:

Картаар үйлчлэгчийг төлөөлж:

Карт эзэмшигчийг төлөөлж:

...../ Т.Оюунбилэг /

..... / /

Албан ёсны хаяг :

“Петровис карт” ХХК

Албан ёсны хаяг:

НИК ХК-ий байр, Ерөнхий сайд Амарын
Гудамж, Сүхбаатар Дүүрэг

Байгууллагын:

УТАС: 70110808,310931,330505

ФАКС: 330808

И-Мэйл: cardcenter@petrovis.mn

ДАНС:

Голомт банк-1102993343

Хаан банк-5059056992

Хас банк-5000010255

ХХБанк – 499185480

Хадгаламж банк-10660003771

УТАС:

ФАКС:

И-Мэйл:

ГАР УТАС:

Картаар үйлчлүүлсэн үнийн дүнгээс олгогдох урамшуулал

Сард худалдан авалтын НӨАТ-гүй үнийн дүнгээс	Урамшууллын хувь	
	Улаанбаатар, Эрдэнэт, Дархан	Орон нутагт
1000,000 хүртэл	1,5%	1,0%
1000,001 – 5,000,000	2,0%	
5,000,001 – 10,000,000	2,5%	1,5%
10,000,001 – дээш	3,0%	

Картаар үйлчилдэг төв суурин газруудын нэрс

Хавсралт № 2

№	Аймаг, хотыннэр	Төв, сумдыннэр	№	Аймаг, хотыннэр	Төв, сумдыннэр
1	Улаанбаатар	Петровис ХХК-ий бүх ШТС-д	11	Ховд	Ховд
		Багануур	12	Баян-Өлгий	Өлгий
		Налайх	13	Дорноговь	Сайншанд
Арвайхээр	Замын үүд				
2	Өвөрхангай	Хархорин	14	Говьсүмбэр	Айраг
		Бат-өлзий			Чойр
		Гучин-Ус	15	Өмнөговь	Даланзадгад
		Хужирт			Нарийн сухайт
		Нарийн тээл			Гурван Тэс
		Зуунмод			Цогтцэций
Жаргалант	Манлай				
3	Төв	Лүн	16	Дундговь	Цогт-Овоо
		Эрдэнэ			Таван толгой
		Эрдэнэсант			
					Цагаанхад /Гашуунсухайт/
		Баянчандмань			Ханбогд
		Туулын гүүр			Мандалговь
		Цэцэрлэг			Эрдэнэдалай
4	Архангай		17	Сүхбаатар	Баруун Урт
		Тариат			
		Эрдэнэмандал			
		Өлзийт			
5	Баянхонгор	Баянхонгор	18	Хөвсгөл	Мөрөн
6	Хэнтий	Өндөрхаан	19	Дархан-Уул	Их Уул
		Жаргалтхаан			Дархан
		Өмнөдэлгэр			Хонгор
					Шарын Гол
7	Дорнод	Бор-Өндөр	20	Сэлэнгэ	Сүхбаатагч
		Чойбалсан			Зүүнхараа
					Хөтөл
					Алтанбулаг
8	Увс	Улаангом	21	Орхон	Сайхан
		Наранбулаг			Баруунхараа
9	Завхан	Улиастай	22	Булган	Орхон
		Их Уул сум			Булган
					Рашаант
		Тосонцэнгэл сум			Хутаг-Өндөр
10	Говь-Алтай	Алтай			Дашинчилэн

Гэрээнд хэрэглэгдэх нэр, томъёо

Ерөнхий данс – Карт эзэмшигч байгууллагын данс бөгөөд уг дансаар дамжуулан картанд цэнэглэлт хийгдэнэ.

КАРТ ЦЭНЭГЛЭЛТ

Карт цэнэглэх – Картанд мөнгө байршуулах

Алсын цэнэглэлт

- **Картын хэрэглэгчийн хүсэлтээр** /утсаар, факсаар/ картын төвөөс хэрэглэгчийн картанд мөнгө байршуулж хэрэглэгч хүлээн авахад бэлтгэж өгөх
- **Картаар үйлчлүүлэгч байгууллага нь** интернэтээр өөрийн ерөнхий данснаас картанд мөнгө хувиарлах буюу картанд мөнгөө хүлээн авахад бэлэн болгох

Картанд мөнгө хүлээж авах- ШТС-д байрлах ПОС машинд картаа уншуулж алсын цэнэглэлтийн мөнгийг картандаа хүлээж авах./Гүйлгээ хийхгүйгээр картаа уншуулж болно/

Мөнгө хүрэхгүй- Картын өдрийн,7 хоногийн, сарын лимит дууссан эсвэл картын үлдэгдэл хүрэлцэхгүй байна.

Карт хар дансанд орох - Ерөнхий дансны мөнгө дуусч карт нь хаагдсан.

ЛИМИТЫН КАРТ, ЛИМИТ ӨӨРЧЛӨХ

- **Лимитын карт** – Шатахууны төрлөөр / ДТ, А80, Ай92, /, хугацаагаар / өдрийн,7 хоногийн, сарын / хязгаар тогтоосон карт.

Лимитын картны гүйлгээний дүнгээрерөнхий данснаас тухайн худалдан авалт хийсэн ШТС-н мэдээ ирэх ббүр хасагдана.

- **Хоногийн лимит**- Картанд тогтоосон лимит нь тухайн нэг өдөрт авах хэрэглээнийхэмжээ байна.
- **7 Хоногийн лимит**- Картанд тогтоосон лимит нь 7 хоногт авах хэрэглээний хэмжээ байна.
- **Сарын лимит**- Картанд тогтоосон лимит нь тухайн сард авах хэрэглээний нийт хэмжээ байна.
- **Картын нийт лимит** – Олон түрийвчтэй картын нийт лимит нь тогтоосон нэг хэмжээтэй байна.

Жишээ нь: А-80 100 литр, Аи-92 100 литр авахаар тогтоогдсон лимиттэй карт нь тухайн сардаа А-80 Аи-92 шатахууныг нийт 100 литрийг авах боломжтой гэж тооцно.

- **Лимит өөрчлөх** – Картаар үйлчлэгч нь тухайн картны лимитыг албан тоотын дагуу өөрчилнө.

Картанд алсын цэнэглэлт, литрийн лимитийг ихэсгэх, багасгах өөрчлөлт оруулсан тохиолдолд 15-20 минутын дараа ШТС-д үйлчлүүлэх боломжтой.

ИНТЕРНЭТ ҮЙЛЧИЛГЭЭ

- **Интернэт код**- Картаар үйлчлэгч байгууллагаас олгосонкодоор картын дэлгэрэнгүй тайлан авах, **ерөнхий данснаас картууд руу хуваарилалт хийх**зэрэг эрх.
Үүнд: Сүүлийн 1 жилийн хугацаан дахь тайлан хамрагдана.
Картаар үйлчлүүлэгч байгууллага нь интернэтээр ерөнхий данснаас картууд руу хуваарилалт хийх нэмэлт цэсийг албан тоотоор итгэмжлэгдсэн ажилтан өөрөө ирж авна.
- **Хэлний сонголт**- Картын тайланг Орос, Англи, Франц, Испани, Украин, Руминхэлээр сонгон авч болно.

УРАМШУУЛАЛ

Урамшуулал- Картаар үйлчлүүлэгч байгууллагын өмнөх сарын хэрэглээнээс хамааран **Хавсралт №1-т** заасан шатлалын дагуу картаар үйлчлэгч байгууллагаас ерөнхий дансанд цэнэглэгдэж өгөх мөнгөн дүн.

КАРТ АШИГЛАХ ЖУРАМ

- Картанд автомашины дугаарыг товойлгон шивүүлсэн тохиолдолд зөвхөн тухайн дугаар бүхийавтомашинд шатахуун олгох болно.

НУУЦЛАЛ

Пин код- Картаар гүйлгээ хийхэд ашиглах нууц дугаар

- PIN кодыг 3 удаа буруу оруулбал карт блоклогдоно.

КАРТ АШИГЛАЛТЫН ГОРИМ

- Ашиглалтын горимыг /механик гэмтэл – 30 градусаас илүүгээр мушгих, нугалах, хугалах, чипыг гэмтээх, норгох, хүчтэй соронзон орны нөлөөлөлд оруулах, хүчил, уусгагч бодисоос хол байлгах г.м / зөрчиж болохгүй. Горимыг зөрчөөгүй тохиолдолд картынашиглагдаххугацаа5 жилбайна.
- Карт эзэмшигч нь картыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, гэмтээсэн тохиолдолд картаарүйлчлэгчид энэ тухай 24 цагийн дотор мэдэгдэж картыг хүчингүйд тооцуулж, хаалгахбөгөөд картанд байгаа мөнгийг ажлын 24 цагийн дараа албан хүсэлтийн дагуу сэргээж шинэ картанд олгоно.

Интернет үйлчилгээ авахад анхаарах зүйл:

1. Эрх бүхий ажилтан картанд мөнгө хувиарласнаас хойш 15-20 минутын дараа ШТС-с шатахуунаа авахад бэлэн болсон байна.
2. Картын багтааж 2 сая тул 2 сая-с илүү цэнэглэлт картанд хийх тохиолдолд хувааж цэнэглэнэ.
3. Жолооч шатахуун авахдаа шатахууны төрлөөр картаа Пос машинд уншуулна. / Ингэж уншуулсанаар тайланд авч буй литр, нэгж үнэ харагдана/.

WEB: www.petrovis.mn/card

Логин:

Парол: